



**НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН АЛБАНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2014 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А101

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын "Төсвийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.5.1, 16.5.2 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ нь:

1. Тус албанаас 2013 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр "Интерсайнс" ХХК-тай байгуулсан "Агаарын бохирдлыг хэмжигч суурин автомат харуулын тоног төхөөрөмжийг шинэчлэх ажил" НХААГ-0299 дугаартай гэрээгээр нийлүүлэн өгсөн Улаанбаатар хотын агаарын чанарын найрлага дахь хүхэрлэг хийн давхар исэл, азотын давхар ислийн агууламж тодорхойлох APSA-370, APNA-370 багажийг хүлээн авах, Нийслэлийн өмчид бүртгэх ажлыг зохион байгуулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд: Ажлын хэсгийн ахлагч: Д.Даваадорж /НАЧА-ны хэлтсийн дарга/

Гишүүд: Д.Жаргалсайхан/НАЧА-ны мэргэжилтэн/

М.Отгонбаяр /НАЧА-ны мэргэжилтэн/

Г.Даваажаргал /НАЧА-ны мэргэжилтэн/

С.Сүхболд /НЗДТГ-ын мэргэжилтэн/

Б.Тэмүүлэн /НӨХГ-ын мэргэжилтэн/

Г.Цэрэннадмид /Нярав/

2. Тухайн багаж хүлээлцэх ажлыг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулж, ажлын тайлан болон акт үйлдэж, үр дүнг 2014 оны 02 дугаар сарын 15-ны дотор албаны удирдлагад танилцуулахыг ажлын хэсэг /Д.Даваадорж/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.БАТСАЙХАН